



“ОМНИ АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот
Утас: +976-70122346; info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

С.Бямбасүрэн /"Омни Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/

Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	5
4. Хавсралт - Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт	7

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Омни Актив ТЗК" ХХК нь 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Омни Капитал ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Омни Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар С.Бямбасүрэн, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр П.Сэлэнгэ, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Нина нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Омни Актив ТЗК" ХХК нь 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр 5 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Омни Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011830497
Регистрийн дугаар	6742904
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/01/12
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	01
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	50,000
ХБҮЦ (сая төг.)	5,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	14.5%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	360 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь 2022 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 543.75 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн бөгөөд үндсэн төлбөрийг төлж эхлээгүй байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/03/03	5,000,000,000	2,500,000,000	181,250,000
2	2023/06/02	2,500,000,000	-	90,625,000
3	2023/09/04	2,500,000,000	-	90,625,000
4	2023/12/04	2,500,000,000	-	90,625,000
5	2024/03/04	2,500,000,000	2,500,000,000	90,625,000
Нийт			5,000,000,000	543,750,000

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 26.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.03.04	2022.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	4,938,921,756.32	3,614,205,569.18	-26.8%
Зээлийн дундаж үлдэгдэл	6,907,582.88	12,816,331.81	85.5%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	4.05%	5.83%	43.8%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	19.77%	24.41%	23.5%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	34.59%	35.79%	3.5%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	62.40%	48.73%	-21.9%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	7.45	8.17	9.7%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	22.67	21.53	-5.0%
Сарын дундаж төлбөрийн дүн	477,644.80	891,574.92	86.7%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	9,108,309.11	6,367,246.09	-30.1%
Зээлийн тоо /нийт/	715	282	-60.6%
Иргэн	711	277	-61.0%
Хуулийн этгээд	4	5	25.0%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ /нийт/	11,718,198,581.74	10,556,590,036.39	-9.9%
Үл хөдлөх	5,280,500,000.00	4,410,000,000.00	-16.5%
Автомашин	5,095,570,576.49	4,833,458,736.39	-5.1%
Хөдлөх хөрөнгө	1,342,128,005.25	1,313,131,300.00	-2.2%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс:	-	4,598,905,889.41*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	3,422,345,541.52	-
Хүүгийн төлбөр	-	1,175,541,367.36	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	1,018,980.53	-

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2022 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 542.24 сая төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Омни Актив ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2022 оны эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 1.23 тэрбум төгрөг, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 11.67 хувь, харилцах дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг байна.

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь "Омни Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	378	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	238	1,862,557,724.90
3	Багцад нэмж бүртгэсэн	183	4,853,400,583.09
	Нийт	799	6,715,958,307.99

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Омни Актив ТЗК” ХХК-ийг “Омни Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2021 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-21/02 тоот шийдвэрээр С.Бямбасүрэн, С.Нина, П.Сэлэнгэ нарын ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн С.Бямбасүрэнг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 9 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2022.01.14	ХБҮЦ гаргахтай холбоотой маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах тухай	Холбогдох төсвийг баталж, талуудтай гэрээ байгуулж гэрээний дагуу төлбөр тооцоо дуусгасан.
2	2022.04.05	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын томилох, ХИУ тайлангийн загварыг батлах тухай	ТУЗ-ийн нарийн даргаар ХИУ сонгож, улирал бүр зохицуулагч байгууллага болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлэх тайлангийн загварыг батлав.
3	2022.04.20	2022 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайланг батлах тухай	2022 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайланг мөн хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2022 оны 4 сарын 20-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт мэдэгдсэн.
4	2022.06.09	ХБҮЦ-ны хэлцэлтэй холбоотой гэрээ журмын нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцэх тухай	ХБҮЦ-ийн хэлцэлтэй холбоотой гэрээ журмын нэмэлт өөрчлөлтийн төслийг хэлэлцэж холбогдох оролцогч талуудаас дахин санал авч ТУЗ-ийн хурлаар хэлэлцэхээр шийдвэрлэв.
5	2022.06.27	ХБҮЦ-ны хэлцэлтэй холбоотой гэрээ журмын нэмэлт өөрчлөлтийн төслийг батлах тухай	Гэрээ журмын төслийн нэмэлт өөрчлөлтийг баталж СЗХ-нд 2022 оны 7 сарын 01-нд мэдэгдсэн
6	2022.07.19	2022 оны 2-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайланг батлах тухай	2022 оны 2-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайланг мөн хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2022 оны 7 сарын 20-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт мэдэгдсэн.
7	2022.09.28	Хөрөнгө итгэмжлэн удирдагчид эх үүсвэрийг хаана, хэрхэн байршуулах талаар боломжит саналуудыг боловсруулан ТУЗ-д танилцуулах Хөндлөнгийн аудитыг солих	Эх үүсвэрийг хаана, хэрхэн байршуулах асуудлаар боломжит саналуудыг боловсруулан Хөрөнгө итгэмжлэн удирдагч, ТУЗ болон Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын холбогдох албан тушаалтныг оролцуулж танилцуулга

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
		үнийн санал авах тухай	хийсэн. Хөндлөнгийн аудитыг солих асуудлын хувьд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 3 аудитын компаниас үнэ авч, үнийг харьцуулсны үндсэн дээр “Юнистар Аудит” компанитай гэрээ байгуулан ТЗК-ийн санхүүгийн тайланд аудит хийлгэх гэрээ байгуулсан.
8	2022.12.12	Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан журамтай холбогдуулан өөрийн дүрэм, журмаа өөрчлөх шаардлага байгаа эсэх, журмын нийцлийг хангах ажлыг “Омни Капитал” ХХК, түүний хуульч П.Урангоод даалгасугай.	Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан журамтай холбогдуулан өөрийн дүрэм, журмаа өөрчлөх шаардлага байгаа эсэх, журмын нийцлийг хангах ажил судалгааны шатанд явж байна.